

Шилэн  
данс

# ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2017 ОНЫ III УЛИРЛЫН БАЙДЛААР

Барилга, хот байгуулалтын яам  
Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар  
2017 он

# АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

Барилга, хот байгуулалтын яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх зарим асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, мөн удирдлагуудыг холбогдох мэдээллээр хангах, холбогдох байгууллага албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.



## АУДИТЫН ЗОРИЛГО

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн, зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх, хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгч зөрчлийг арилгахад оршино.

## Шалгуур

- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол



- Барилга, хот байгуулалтын сайдын баталсан төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын багцын төсөвт байгууллага, ТӨААТҮГ, ТӨҮГ, УТҮГ, төсөл хөтөлбөрүүдийн шилэн дансны хуулийн хэрэгжилт, тайлан, мэдээг хуулийн хугацаанд үнэн, зөв, иж бүрэн байршуулж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх, хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор мэдээллийг нэгтгэн авч үзлээ.



## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН БАГЦЫН

### 12 БАЙГУУЛЛАГЫГ АУДИТАД ХАМРУУЛСАН.

#### ТЕЗ, түүний харьяа байгууллагуудын шилэн дансны нэгдсэн сайтад илгээсэн тайлан мэдээллийн нэгтгэл

дд	Байгууллагын нэр	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо		Мэдээлээгүй /тоо/				Хэрэгж илт хувь
			Хугацаандаа	Хугацаа хоцроосон	Төсөв/ гүйцэтгэл	ХО, тендер, ху/авал т	Бусад	Дүн	
1	Сайд ТЕЗ	59	26	28	2	1	2	5	91.5%
2	Барилга, хот байгуулалтын яам	70	34	33	2	-	1	3	95.7%
3	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	71	46	20	4	-	1	5	92.9%
	<b>Дүн</b>	<b>200</b>	<b>106</b>	<b>81</b>	<b>8</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>13</b>	<b>93.5%</b>



## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР-6

дд	Байгууллагын нэр	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо		Мэдээлээгүй /тоо/				Хэрэгжилт хувь
			Хугацаанд аа	Хугацаа хоцроосон	Төсөв/ гүйцэтгэл	ХО, тендер, ху/авал т	Бусад	Дүн	
4	"Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах" төсөл	71	39	30	1	-	1	2	97.1%
5	"Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244, МОН 3245 төсөл"	79	34	43	1		1	2	97.5%
6	"Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл" төсөл	70	62	8	-	-	-	-	100%
7	"Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ орчмын хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл"	80	49	30	1	-	-	1	98.7%
8	Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл G0204-MON	70	10	41	10	9	-	19	72.8%
9	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл L3388-MON	79	15	64	-	-	-	-	100%
<b>Дүн</b>		<b>449</b>	<b>209</b>	<b>216</b>	<b>13</b>	<b>9</b>	<b>2</b>	<b>24</b>	<b>94.6%</b>

## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА ТӨААТҮГ, ТӨҮГ, УТҮГ

дд	Байгууллагын нэр	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо		Мэдээлээгүй /тоо/				Хэрэгжилт хувь
			Хугацаандаа	Хугацаа хоцроосон	Төсөв/ гүйцэтгэл	ХО, тендер, ху/авалт	Бусад	Дүн	
10	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	68	25	39	2	1	1	4	94.1%
11	Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ	76	10	55	6	1	4	11	85.5%
12	Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл	14	1	9	3	-	1	4	71.4%
	<b>Дүн</b>	<b>158</b>	<b>36</b>	<b>103</b>	<b>11</b>	<b>2</b>	<b>6</b>	<b>19</b>	<b>87.9%</b>
	<b>ТЕЗ-ийн багцын нэгдсэн дүн</b>	<b>807</b>	<b>351</b>	<b>400</b>	<b>32</b>	<b>12</b>	<b>12</b>	<b>56</b>	<b>93.0%</b>



## ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСАНД МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ГАРЧ БУЙ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн дүнгээр 93,0 хувьтай хэрэгжүүлсэн боловч тайлан мэдээллийг хуульд заасан хугацаа хэтрүүлэх зөрчил нийтлэг байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмуудыг хангахгүй байна.





# Хуульд Заасан Хугацааны Хэрэгжилт Хувь

дд	Байгууллагын нэр	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо		Мэдээлээгүй /тоо/	Хуульд заасан хугацааны хэрэгжилт хувь
			Хугацаанд аа	Хугацаа хоцроосон		
1	Сайд ТЕЗ	59	26	28	5	44.1%
2	Барилга, хот байгуулалтын яам	70	34	33	3	48.6%
3	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	71	46	20	5	64.8%
	Дүн	200	106	81	13	53.0%
4	"Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах" төсөл	71	39	30	2	54.9%
5	"Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244, МОН 3245 төсөл"	79	34	43	2	43.0%
6	"Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл" төсөл	70	62	8	-	88.6%
7	"Улаанбаатар хотын VII, XIV, МУОНРТ орчмын хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл"	80	49	30	1	61.3%
8	Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл G0204-MON	70	10	41	19	14.3%
9	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл L3388-MON	79	15	64	-	19.0%
	Дүн	449	209	216	24	46.5%
10	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	68	25	39	4	36.8%
11	Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ	76	10	55	11	13.2%
12	Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл	14	1	9	4	7.1%
	Дүн	158	36	103	19	22.8%
	<b>ТЕЗ-ийн багцын нэгдсэн дүн</b>	<b>807</b>	<b>351</b>	<b>400</b>	<b>56</b>	<b>43.5%</b>

2. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнах ёстой ба ихэнх байгууллага мэдээлээгүй, шилэн дансны нэгдсэн сайтад тайлан илгээгээгүй байна.

3. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр оруулсан боловч шалтгаан тайлбарыг мэдээлээгүй.

4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг оруулсан боловч холбогдох шийдвэрийн хуулбарыг оруулаагүй.

5. Цахим сайтад байршуулсан PDF файлууд нь нээгдэхгүй, нээгдсэн ч уншигдахгүй, үсэг фонд нь танигдахгүй байгаа нь хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмуудыг хангахгүй байна.



# ДҮГНЭЛТ

- Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагуудын шилэн дансны нэгдсэн сайтад тайлан, мэдээлэл байршуулсан байдлыг хэрэгжилтийн хувиар авч үзвэл 60-80 хүртэл хувьтай 2 байгууллага, 80-100 хүртэл хувьтай тайлан мэдээллээ байршуулсан 8 байгууллага байна. Үүнээс харвал харьяа байгууллагууд шилэн дансны нэгдсэн сайтад тайлан мэдээллээ тогтмол байршуулж хэвшсэн байна.
- Харьяа төсөвт байгууллагуудын цахим хуудсанд байршуулсан зарим тайлан мэдээлэл дутуу, чанаргүй, нээгдэх боломжгүй байгаа нь нэгж байгууллагын эрх бүхий ажилтнуудад мэдээлэл, арга зүйн сургалт зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.



# ЗӨВЛӨМЖ

## Харьяа байгууллагуудын төсөв захирагч нарт:

- Шилэн дансны хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах;
- Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг албан хэрэг хөтлөлтийн журамд заасан үсгийн фонтоор, хууль, журамд заасан хугацаанд ойлгомжтой, ач холбогдолтой байхаар тогтмол, шуурхай мэдээлэх;
- Шилэн дансны админ болон мэдээлэл оруулах албан хаагчдын чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээнд тусгаж хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Шилэн дансны улирлын тайланг тогтоосон хугацаанд илгээж хэвших;

## Яамны Төрийн захиргааны удирдлагын газарт:

- Агентлаг, харьяа байгууллагуудын төсөв захирагч нартай байгуулах үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар тусгаж үр дүнг тооцож ажиллах;